

“Дэвшил Мандал” ХК-нийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын дэг

1	Хурлын ирц бүртгэл (ажлын хэсэг)	09:30-10:00
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	5 минут
3	Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	15 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах, хураах	90 минут
5	Хурлын завсарлага	15 минут
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	15 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	15 минут
8	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал урьдчилсан байдлаар 2 цаг 40 мин үргэлжлэхээр төлөвлөгдөж байна.

Хурал зохион байгуулах комисс

# “ДЭВШИЛ МАНДАЛ” ХК

“Дэвшил Мандал” ХК-ний 2015 оны хувьцаа  
эзэмшигчдийн ээлжит хурлын танилцаж болох  
баримт бичгийн жагсаалт

1. Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Саналын хуудсын загвар
3. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө, төсөл
4. ТҮЗ-ийн хараат болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсонтой холбогдуулан гаргасан шийдвэр, тогтоолууд



# “ДЭВШИЛ МАНДАЛ” ХК

Дундговь аймаг,  
Саянчөлөгчийн балгас  
89428992

2015.04.20

Дугаар 05/11

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц  
болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн  
ТОГТООХ НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн хуралд 60309 ширхэг хувьцаа эзэмшдэг 4 хувьцаа  
эзэмшигчид өөрийн биеэр оролцсон нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны  
85.64 хувь болж байгаа тул компанийн 2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССИЙН ДАРГА

Ө. Чулуунтогтох



# “ДЭВШИЛ МАНДАЛ” ХК

Дундговь аймаг,  
Улаанбаатар хот  
89428992

2015.04.20

Дугаар 01/08

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх хэсэг, 2015 оны 04 дүгээр сарын 20 -ийн өдрийн тооллогын комиссын 05/12 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

2015 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн санхүүгийн өнөөгийн байдлын талаар хувьцаа эзэмшигчдийн дүгнэснийг үндэслэн, 2014 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



. С. Энхмандах

# “ДЭВШИЛ МАНДАЛ” ХК

Дундговь аймаг,  
Саянчөлөгчинь 89428992

2015.04.20

Дугаар 01/09

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигдийн хурлын шийдвэр  
хүчингүй болсон тухай


Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэг, 2015 оны 04 дүгээр сарын 20-  
ний өдрийн тооллогын комиссын 05/12 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ  
НЬ:

Компанийн үнэт цаасны арилжааны талаар хэлэлцэж батлах талаарх хувьцаа  
эзэмшигчдийн өгсөн саналыг үндэслэн хурлын шийдвэрийг хүчингүйд тооцсугай.

Дээрх асуудалтай холбогдуулан төсөл боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн ээжит  
бус хурлыг зарлан хуралдуулж, уг хурал дээр төслийг танилцуулан хэлэлцүүлж  
шийдвэрлэх ажлыг шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С. Энхмандах



2015.04.20

Дугаар 01/10

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг шинээр болон улираан  
сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйл 77.1, 77.2  
дахь хэсэг мөн 2015 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн тооллогын  
комиссын 05/13 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг  
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

ТҮЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид:

1.10. С. Амармандах	60309 ш (100%)
1.11. Я. Өлзий-Утас	60309 ш (100%)
1.12. С. Мөнхбат	60309 ш (100%)
1.13. С. Энхмандах	60309 ш (100%)
1.14. М. Амарбаяр	60309 ш (100%)
1.15. Я. Сэлэнгэ	60309 ш (100%)

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг  
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.
  - a. Ц. Баянмөнх 60309 ш (100%)
  - b. Н. Сүхбаатар 60309 ш (100%)
  - c. М. Бат-Амгалан 60309 ш (100%)
3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ  
хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг  
болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



С. Энхмандах